



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/316

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажил (Бугат, Орхон, Сэлэнгэ, Дашинчилэн, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)”-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Векормэп” ХХК-тай 308,900,000 (гурван зуун найман сая есөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Векормэп” ХХК-ийн захирал (М.Басцагаан)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг тус сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010435

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 30-ны/ний өдрийн
А/316 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт




Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
2	Захиалагчийн техникийн хяналтын зардал	Нийт зардлын 5 хувь	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
3	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
 01 дүгээр сарын 20-ны/ний өдрийн
 ...А/316 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Төслийн удирдагч	Ш.Наран-Очир	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Хот төлөвлөлтийн архитектор	Б.Батцэцэг	
3	Газар зохион байгуулагч инженер	Б.Алтанцэцэг	
4	Газар зохион байгуулагч инженер	Р. Жамъянмядаг	
5	Газрын кадастр инженер	М.Басцагаан	
6	Байгаль орчин, хүрээлэн буй орчны инженер	Б.Ганзориг	
7	Геодезийн инженер	Б.Уянга	
8	Агрономич	Я.Баасандорж	
Машин механизмын жагсаалт			
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар, нэр	
1	Туулах чадвар сайтай автомашин	1580 УБЕ 9664 УБС	Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)
2	Туулах чадвар сайтай автомашин	1117 УАХ 9148 УБА	
3	Өндөр нарийвчлалын GNSS-ийн багаж-2	South S82-v gnss HuaceNav X20	
4	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж-1	MATRICE 300 RTC PHANTOM 4 RTC	
5	Вектор болон растер зураг боловсруулах програм хангамж	Quiantum GIS ArcGIS Desktop Arc Info /Workstation/ ARC Reader Arc Spatail analyst	

--o00o--